



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 1110

Чойбалсан

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг нэмэлт дархлаажуулалтыг эрчимжүүлэх нэг сарын аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.1.4 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/564 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг нэмэлт тунгийн хамралтыг эрчимжүүлэх "Нэг сар"-ын аяныг 2022 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2022 оны 05 сарын 10-ны хооронд зохион байгуулсугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг нэмэлт тунгийн хамралтыг эрчимжүүлэх аяны удирдамжийг нэгдүгээр, үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нэмэлт тунгийн хамралтыг нэмэгдүүлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж, дархлаажуулалтын ач холбогдлын талаар олон нийтийн мэдээллийн сүлжээ, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.


4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв (Б.Сарнай)-д даалгасугай.

ДАРГА



Ч.ОЮУНАА

Эрүүл мэндийн газрын дарга 2022 оны
04 дугаар сарын 13-ны өдрийн
1/10 дугаар/дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ НЭМЭЛТ ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ НЭГ САРЫН АЯНЫ УДИРДАМЖ

Үндэслэл: Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр “Олон улсын шинж чанартай нийгмийн эрүүл мэндийн онц байдал”, 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдөр “Цар тахал” болсныг зарласан. ДЭМБ-ын SARS- CoV-2 вирусийн хувьсалыг судлах Зөвлөх хорооны шийдвэрээр “Онцгой анхаарал татах хувилбар”-ын вирусын ангилалд Альфа, Бета, Гамма, Дельта хувилбарын вирус хамаарч байна.

Манай улсад 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Коронавируст халдвар (Ковид-19)-ын анхны зөөвөрлөгдсөн тохиолдол, 11 дүгээр сарын 11-ний өдөр дотоодын халдвар бүртгэгдсэн анхны тохиолдлыг тус тус зарласан. Одоогоор Коронавируст халдвар (Ковид-19)-ын 4 дэх удаагийн давалгаа буурч, халдварын тархалт “Ногоон” түвшинд шилжиж, өвчлөлийн тохиолдол буурч байна.

2021 оны 02 дугаар сараас эхлэн Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтыг Монгол Улсад хийж эхэлсэн бөгөөд 2022 оны 04 дүгээр сарын 01-ний байдлаар зорилтот бүлгийн хүн амын 1-р тунгийн хамралт 96.4 хувь, 2-р тунгийн хамралт 92.3 хувь, 3-р тунгийн хамралт 53.0 хувь, нийт хүн амын 1-р тунгийн хамралт 69.9 хувь, 2-р тунгийн хамралт 66.8 хувь, 3-р тунгийн хамралт 31.8 хувьтай байна.

2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг 3 дугаар тунгийн зорилтот бүлгийн хамралт улсын хэмжээнд 53.0 хувьтай байна.

Дорнод аймагт 2022 оны 04 дүгээр сарын 01-ний байдлаар зорилтот бүлгийн хүн амын 1-р тунгийн хамралт 93.0 хувь, 2-р тунгийн хамралт 89.6 хувь, 3-р тунгийн хамралт 60.9 хувь, нийт хүн амын 1-р тунгийн хамралт 67.0 хувь, 2-р тунгийн хамралт 64.6 хувь, 3-р тунгийн хамралт 34.0 хувьтай байна.

Зорилт: Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг 3 дугаар тунгийн хамралтыг эрчимжүүлэх “Нэг сар”-ын аян зохион байгуулж, хамралтыг 10-15 хувиар нэмэгдүүлэх.

Хугацаа: 2022 оны 4 дүгээр сарын 10-наас 5 дугаар сарын 10-ны хооронд

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг нэмэлт дархлаажуулалтыг эрчимжүүлэх орон нутгийн онцлог тохирсон “бичил төлөвлөлт”-ийг гаргаж хэрэгжүүлэх;

2.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын талаарх хүн амын ойлголт, хандлагад суурилан мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах;

3.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг нэмэлт дархлаажуулалтын хамралтыг эрчимжүүлэх мэдээлэл сурталчилгааг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах;

4.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг нэмэлт дархлаажуулалтын хамралтын хувь бага байгаа 18-39 насны хүн амд чиглэсэн мэдээлэл сурталчилгааг зохион байгуулах;

5.Орон нутгийн онцлогт тохируулан дархлаажуулалтын явуулын баг ажиллуулах;

6.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг нэмэлт дархлаажуулалт зохион байгуулсан тухай тайланг ирүүлэх.

Үр дүн:

2022 оны 04 дүгээр сарын 10-наас 2022 оны 05 дугаар сарын 10-ны хооронд “Нэг сар”-ын хугацаанд коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг нэмэлт дархлаажуулалтын хамралтын хувийг зорилтот түвшинд /68%/ хүргэнэ.

ooOoo